



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/53/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
Санхүүгийн тайлангийн аудитын хугацаа бага байсан ба дараагийн аудитаар төсөл хөтөлбөрөөр худалдан авсан хөрөнгө, хийгдсэн ажлыг тодруулан үзэх шаардлагатай гэж үзлээ.	11
2.13. Шилэн дансны мэдээлэл	11
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
Менежментийн захидал	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	15
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	21



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН НОМУНДАЛАЙ
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

АЧЛ.ОД.Д.О № 1137

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн, дотуур байрны хүүхдийн ирцэд дотуур байранд байхгүй, гарсан хүүхдүүдийг бүртгэж, зардлаар тайлагнасан, аудитын явцад үнэн зөв мэдээлэл өгөөгүй, тэтгэвэрт гарсан багш, ажиллагсдыг ажиллуулахдаа

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020080


хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, цалингийн шатлалаар цалинжуулж, нэмэгдэл хөлс олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлж, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 21.1 сая төгрөгийн цалинг олгож, зардал хооронд гүйлгэн зарцуулсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.3 дахь "Төрийн жинхэнэ албан хаагчийг дараах үндэслэлээр төрийн албанаас чөлөөлнө. төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн" зэрэг заалтуудыг зөрчсөн байна. Энэ нь "Аж ахуйн нэгж, байгууллагад бүртгэгдсэн ажил гүйлгээ буюу үйл явдал нь тухайн тайлант хугацаанд бодитой болж өнгөрсөн байх" **Тохиолдсон байх**, "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" **Үнэн зөв байдал** гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Ц.Алтангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 12-ноос 2020 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай албан бичгийг 2020 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сурагч бүрийн сурлагын чанарт ахиц гарган, хүүхдийн эрхийг дээдэлж, багийн үйл ажиллагааг эрхэмлэсэн сургалт төлөвшил хөгжлийн төв бүхий сургууль байх”-д оршино.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургууль нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг “Сурагч бүрийн сурлагын чанарт ахиц гарган, хүүхдийн эрхийг дээдэлж, багийн үйл ажиллагааг эрхэмлэсэн сургалт төлөвшил хөгжлийн төв бүхий сургууль байх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 43 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous 4.10, цалингийн Payroll" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 37 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн, зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1 хувиар буюу 24869.3 мянган төгрөгөөр тооцож баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 35425.5 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 10556.2 мянган төгрөгөөр өссөн нь төлөвлөлтийн шатанд Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 он 03 дугаар улирлын санхүүгийн тайланг татсантай холбоотой байна.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5218593,3 мянган төгрөгөөр буюу 70 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	2,617.03	629.43	(1,987.60)
УРЬДЧИЛГАА	-	2.75	2.75
БАРАА МАТЕРИАЛ	157,436.41	171,207.41	13,771.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,199,826.38	3,007,086.70	(192,739.68)
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(742,092.26)	(720,418.48)	21,673.78
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,617,787.56	2,458,507.81	(159,279.75)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,699.26	362.20	(1,337.06)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,616,088.30	2,458,145.61	(157,942.69)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,617,787.56	2,458,507.81	(159,279.75)

Тус байгууллага Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй оны эцэст 362.2 мянган төгрөгийн өглөг, 1987.6 мянган төгрөгийн авлагатай ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 13771.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 171207.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба энэ нь бичиг хэргийн болон барилгын засварын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 192739.6 мянган төгрөгөөр буурч оны эцэст 3007086.7 мянган төгрөг болсон нь тайлант онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2 удаагийн тогтоолоор 256245.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 63506.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд анх 2986541.5 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 3, 9, 11, 12 саруудад төсвийг нэмж тодотгож, төсвийг анх батлагдсанаас 294111.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,

төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 7 арга хэмжээний зардалд зориулан 3280653.0 мянган төгрөгийн төсөв баталснаас гүйцэтгэлээр 3278619.9 мянган төгрөгийг зарцуулж, 2033.1 мянган төгрөгийг хэмнэснийг оны эцэст төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь түлш халаалтын зардлыг 58.3 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 472.0 мянга, үдийн цайны зардал 1485.5 мянга, бараа материалын зардлыг 17.3 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, хэмнэлтийг оны эцэст төсөвт төвлөрүүлжээ

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуульд 2019 онд өөрийн орлогын төлөвлөгөө байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар гүнзгий ангийн сургалтын төлбөрийн орлогоор 19689.3 мянга, түрээсийн орлогоор 4350.0 мянган төгрөг орж, аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас 5 жилийн тэтгэмжийн 19810.2 мянга, түрээсийн сурах бичгийн 1565.7 мянга, бага ангийн багш нарын хэрэгжүүлсэн тэтгэлэгт хөтөлбөрийн төсөлд 34332.0 мянган, нийт 79747.8 мянган төгрөгийн орлого орсон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 44 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 22 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 37 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 10 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

1. Үр дүнгийн тайланд үдийн цайны 88100.2 мянган төгрөгийн зардлыг хоолны зардлыг тайлагнасан алдааг үр дүнгийн тайланд хоолны зардлыг бууруулж, үдийн цайны зардлыг нэмэгдүүлж аудитлагдсан тайланд залруулав.

2. Ажиллагсдаас суутгасан татвар, хувь хүнээс худалдан авсан барааны үнээс суутгасан 10%-ийн татварын татварын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ба Татварын хэлтсийн 2019 оны 4 дүгээр улирлын тайлангаар 39.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайланд татварын авлагыг 99.4 мянган төгрөгөөр буюу 59.6 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн зөрчил илэрсэнд авлагыг бууруулж залруулав.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	71.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	4	14.1	
3	Албан шаардлага өгсөн	1	7.0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	8	92.2	

Аудитаар нийт 92280.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 14163.3 мянган төгрөгийн 4 алдаанд төлбөрийн акт тогтоож, 7000.0 мянган төгрөгийн 1 алдаанд албан шаардлага өгч, 71117.4 мянга төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардлын төсвөөс хэмнэгдсэн зардлыг тайлант хугацааны эцэст төвлөрүүлэлгүй их хэмжээний худалдан авалт хийж үдийн цайны зардлаас 734.0 мянган төгрөгийн 111,5 кг мах, дотуур байрны хоолны зардлаас 925.7 мянган төгрөгийн ааруул, хар чавга зэрэг хүнсний бүтээгдэхүүнийг нөөцөлж бэлдсэн байгаа нь хадгалалтын хугацаа алдагдах, чанар байдал өөрчлөлт орох хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал хангахгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн тооллогоор дутагдсан хөрөнгө байхгүй боловч нягтлан бодогч хөрөнгийн тооллогыг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй байна. Оны эцэст аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс тавилга худалдан авах зардалд 10500.0 мянган төгрөгийг хуваарилж, нэг бүрийг нь 150.0 мянган төгрөгийн үнэ бүхий нийт 70 ширхэг ор авах төсвийг баталжээ. Үүнээс 7000.0 мянган төгрөгийг “Мөнх оргилын жигүүр” хоршоонд шилжүүлж, сургуулийн захирал тус хоршооны дарга И.Алтангадастай 2019/03 тоот гэрээг 2019.12.19-ний өдөр байгуулж, нэг бүрийг нь 100.0 мянган төгрөгөөр нийт 70 ширхэг ор авахаар захиалж, 2020.01.20-ны өдөр хүлээлгэж өгөхөөр заажээ. Тус хөрөнгийг нягтлан бодогч бүртгэлд орлогоор тусгасан бөгөөд аудитын явцад хийсэн биет тулгалтаар байхгүй байсан зөрчил илэрлээ.

Энэ нь Тохиолдсон байх, оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөв.

2.11.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Тайлант онд ажиллагсдаас 255323.4 мянган төгрөгийн НДШ-ийг суутгасан атлаа 255662.1 мянган төгрөгийг шилжүүлж, 338.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн нь ажиллагсдаас НДШ-ийг зөрүүтэй тооцож суутгасантай холбоотой байна.



Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.4 Зардлын данстай холбоотой асуудал

Тус сургуульд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2019 онд 167 орон тоо баталсан ба тус орон тоонд захиргаа аж ахуйн дарга, хүний нөөцийн ажилтан, статистикч, хөгжмийн техникч гэсэн орон тоо батлагдаагүй, ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг тулган шалгахад дээрх албан тушаалын ажлын байрны тодорхойлолт байхгүй байхад 4 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний 30 хувийн нэмэгдэлд 2833.3 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.1.5 Залилангийн эрсдэл

Дотуур байрны багш нарын ирцийн бүртгэл дутуу, хүүхдийн ирцийг өдөр бүрээр, хүүхэд бүрээр дүгнэж гаргаагүй, эцэг эхтэй байгуулсан гэрээг шалгахад 67 хүүхдийн гэрээг ирүүлсэн бөгөөд ирүүлсэн гэрээг сургуулийн захирал, байрны багш албажуулаагүй, өмнөх онуудад байгуулсан гэрээтэй, захирлын баталсан 7 хоногийн хоолны цэсийг өдөр бүрийн жижүүр хүүхдийн тэмдэглэлтэй тулгахад батлагдсан цэсээс өөр хоол олгосон байна. Аудитын явцад ахлах ангийн багш нараас авсан мэдээлэл, нярвын тайлан, дотуур байрны багшийн бүртгэлээр 2019 оны 1-5 сард 160, 9-12 сард 190 хүүхэд бүртгэлтэй байхад анхан шатны баримтыг шалгах явцад дотуур байранд амьдардаг 120 хүүхдийн дунд тэмцээн явуулсан тайлан хавсаргасан, аудитын явцад дотуур байрны багш нарын гаргасан судалгааг тасгийн гаднах нэрстэй тулгахад зарим хүүхдийн нэрс байхгүй, зөрүүтэй байгаа ба энэ нь дотуур байранд амьдардаггүй 36 хүүхдийг бүртгэлд оруулж бүртгэн, хоолны зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Үнэн зөв байдал, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын хугацаа бага байсан ба дараагийн аудитаар төсөл хөтөлбөрөөр худалдан авсан хөрөнгө, хийгдсэн ажлыг тодруулан үзэх шаардлагатай гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

Төсвийн гүйцэтгэл/бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр/-ийг 6,9,12 саруудад хоцроож мэдээлсэн, тухайн жилийн төсвийн төсөл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, дараа жилийн төсвийн төсөл зэргийг хугацаа хоцроож мэдээлсэн, орлогын дүнг бөөнд дүнгээр мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4	-	-
3	Улирал бүр	1	4	-	4	-
4	Сар бүр	3	36	36	-	
5	Тухай бүр	8	96	78	18	
	Нийт	27	151	125	24	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар акт, албан шаардлага тогтоогоогүй ба аудитаар 2 зөвлөмж өгсөн байна. Байгууллага зөвлөмжийн хариуг 2019.06.12-ний өдөр 241 албан тоотой ирүүлсэн бөгөөд аудитаар зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна гэж үзлээ.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт АБ-18-д хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Баянхонгор сумын Номундалай цогцолбор сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

3.1.1 Илрүүлэлт:

Түүврийн аргаар өндөр настны тэтгэвэрт гарсан ажиллагсдыг тулган шалгахад нийгмийн даатгалын мэдээнд өндөр настны тэтгэвэрт гарсан 2 ажилтныг “тэтгэвэр тогтоолгосны дараа ажиллаж байгаа ажилтан” 22 кодоор мэдээлэх байтал “аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан” 01 кодоор буруу мэдээлсэн байна.

Мөн тэтгэвэрт гарсан 2 багшийг ажиллуулахдаа ТҮБД-3-1 шатлалаар цалинжуулж, анги даалт, кабинет, 90-р тогтоол, зэргийн нэмэгдэл олгосон байна.

